

ДОТООД АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, 2024 оны 214 дүгээр тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хууль зүйн яам, түүний харьяа агентлаг, байгууллагын дотоод аудитын журам”-ын хүрээнд байгууллагын даргын энэ оны 01-08/06 дугаар удирдамжийн дагуу 2025 оны хоёрдугаар улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Байгууллагуудыг дэлгэрэнгүйгээр өссөн дүнгээр харуулбал:

д/д	Байгууллагууд	Системд бүртгэлтэй байгууллагын тоо	Мэдээлэх давтамж	Хугацаандаа	Хугацаа хоцорсон мэдээлэл	Хугацаа болоогүй	Хувь
1	2	3	4	5	5	6	7
1	Гадаадын иргэн, харьяатын газар	1	87	86	1	-	98.8
2	Агаарын замын боомт хариуцсан газар	1	87	87	-	-	100.0
3	Дорноговь аймаг дахь газар	1	87	87	-	-	100.0
4	Хойд бүс дэх газар	1	87	87	-	-	100.0
5	Өмнөд бүс дэх газар	1	87	87	-	-	100.0
6	Баруун бүс дэх газар	1	87	87	-	-	100.0
7	Зүүн бүс дэх газар	1	87	87	-	-	100.0
8	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	1	87	87	-	-	100.0
Нийт дүн		8	696	695	1	-	99.8

Байгууллагын хэмжээнд тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа санхүүгийн үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалтын холбогдох мэдээллийг цахим хуудсанд 3 ангиллаар 29 төрлийн 696 мэдээлэл байршуулахаас 695 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулан 99.8 хувийн хэрэгжилттэй буюу “Хангалттай” хэмжээнд байна.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлж, хуулийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай. Үүнд:

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах, байршуулж буй мэдээллийн чанар, агуулга, үнэн зөв, иж бүрэн байдалд анхаарал хандуулж ажиллах;

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, тушаалыг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлэх;

Тушаал, шийдвэр батлан гаргахдаа Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг баримтлан ажиллах;

Дотоод аудитын зөвлөмж, удирдлагаас хүргүүлсэн үүрэг чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах тул холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

---00000000---